



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/52/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Ахлах аудитор Б.Азхүү Утас: 9985-8616 Цахим хаяг: Azkhuub@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг /Local.audit.mn сайтад шивсэн/ баримтжууллаа.	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС

Улсын Секторын Нягтлан Бодох
Бүртгэлийн Олон Улсын
Стандарт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын
Олон Улсын Стандарт

ТЕЗ

Төсвийн ерөнхийлөн захирагч



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.01.13 № 68
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
С.БАТТУЛГА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,637,938.50	10,008,438.50
35	БАРАА МАТЕРИАЛ	8,637,938.50	10,008,438.50
35400	Хангамжийн материал	8,637,938.50	10,008,438.50
35420	Аж ахуйн материал	8,037,938.50	8,008,438.50
35440	Түлш, шатах тослох материал	600,000.00	2,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	42,855,512.02	44,294,230.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	42,855,512.02	44,294,230.16
39200	Биет хөрөнгө	41,455,512.02	42,894,230.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	32,269,769.17	32,269,769.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,892,867.76	-20,018,501.64
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,813,373.00	17,182,123.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,956,549.40	-6,573,430.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,801,197.00	2,801,197.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,247,913.99	-1,501,731.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	403,990.00	403,990.00
39217	Ном	18,264,514.00	18,330,814.00
39300	Биет бус хөрөнгө	1,400,000.00	1,400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,400,000.00	1,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	51,493,450.52	54,302,668.66
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	51,493,450.52	54,302,668.66
51	Засгийн газрын хувь оролцоо	51,493,450.52	54,302,668.66
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	54,286,331.00	54,286,331.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-64,484,507.18	-61,675,289.04
51210	Өмнөх үеийн үр дүн	-60,030,181.14	-64,484,507.18
51220	Тайлант үеийн үр дүн	-4,454,326.04	2,809,218.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,691,626.70	61,691,626.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	51,493,450.52	54,302,668.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	69,320,400.00	83,865,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,000.00	7,946,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	80,000.00	7,946,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	7,946,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	69,240,400.00	75,919,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,240,400.00	75,919,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,240,400.00	75,919,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	73,774,726.04	81,056,531.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,774,726.04	81,056,531.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,394,690.34	76,312,445.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,409,100.00	52,577,696.00
210101	Үндсэн цалин	52,409,100.00	52,577,696.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,075,199.30	7,187,118.00
210201	Тэтгэврийн даатгал	4,978,899.30	5,043,131.00
210202	Тэтгэмжийн даатгал	524,100.00	538,297.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	419,300.00	435,038.00
210204	Ажилгүйдлийн даатгал	104,700.00	106,061.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,048,200.00	1,064,591.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,880,200.00	6,399,920.00
210301	Гэрэл, цахилгаан	558,500.00	1,029,500.00
210302	Түлш, халаалт	4,221,700.00	5,270,420.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	893,170.00	751,780.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00
210402	Тээвэр, шатахуун	344,665.00	495,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	412,005.00	119,300.00
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,600.00	70,600.00
210702	Дотоод албан томилолт	70,600.00	70,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	595,504.00	180,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	370,004.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	145,500.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,321,917.04	8,996,331.86
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,321,917.04	8,996,331.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	380,035.70	4,744,086.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	265,400.00	438,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	265,400.00	438,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	114,635.70	4,305,286.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	114,635.70	4,305,286.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-4,454,326.04	2,809,218.14
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,454,326.04	2,809,218.14

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	54,286,331.00	61,691,626.70	-60,030,181.14	55,947,776.56
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	54,286,331.00	61,691,626.70	-60,030,181.14	55,947,776.56
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-4,454,326.04	-4,454,326.04
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	54,286,331.00	61,691,626.70	-64,484,507.18	51,493,450.52
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	54,286,331.00	61,691,626.70	-64,484,507.18	51,493,450.52
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	54,286,331.00	61,691,626.70	-64,484,507.18	51,493,450.52
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,809,218.14	2,809,218.14
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	54,286,331.00	61,691,626.70	-61,675,289.04	54,302,668.66

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	69,320,400.00	75,919,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	80,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	69,240,400.00	75,919,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,240,400.00	75,919,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,240,400.00	75,919,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,254,100.00	73,430,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,254,100.00	73,430,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,874,064.30	68,686,614.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,409,100.00	52,577,696.00
210101	Үндсэн цалин	52,409,100.00	52,577,696.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,075,199.30	7,187,118.00
210201	Тэтгэврийн даатгал	4,978,899.30	5,043,131.00
210202	Тэтгэмжийн даатгал	524,100.00	538,297.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	419,300.00	435,038.00
210204	Ажилгүйдлийн даатгал	104,700.00	106,061.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,048,200.00	1,064,591.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,921,700.00	7,921,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.00	1,000,000.00
210302	Түлш, халаалт	4,821,700.00	6,821,700.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	600,465.00	600,500.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00
210402	Тээвэр, шатахуун	344,665.00	344,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00

Жаргалант сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,600.00	70,600.00
210702	Дотоод албан томилолт	70,600.00	70,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000.00	180,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	145,500.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	380,035.70	4,744,086.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	265,400.00	438,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	265,400.00	438,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	114,635.70	4,305,286.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	114,635.70	4,305,286.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	66,300.00	2,488,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	66,300.00	2,488,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,300.00	2,488,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	66,300.00	2,488,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	66,300.00	2,488,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-66,300.00	-2,488,500.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	75,919,200.00	71,613,914.00	4,305,286.00	94.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75,919,200.00	71,613,914.00	4,305,286.00	94.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,480,400.00	71,175,114.00	4,305,286.00	94.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,409,100.00	52,577,696.00	3,831,404.00	93.2
210101	Үндсэн цалин	56,409,100.00	52,577,696.00	3,831,404.00	93.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,615,200.00	7,187,118.00	428,082.00	94.4
210201	Тэтгэврийн даатгал	5,358,900.00	5,043,131.00	315,769.00	94.1
210202	Тэтгэмжийн даатгал	564,100.00	538,297.00	25,803.00	95.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	451,200.00	435,038.00	16,162.00	96.4
210204	Ажилгүйдлийн даатгал	112,800.00	106,061.00	6,739.00	94.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,128,200.00	1,064,591.00	63,609.00	94.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,921,700.00	7,921,700.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	6,821,700.00	6,821,700.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	666,800.00	666,800.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	344,700.00	344,700.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00	0.00	100.0

Жаргалант сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	70,600.00	70,600.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	70,600.00	70,600.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000.00	2,602,200.00	45,800.00	98.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	2,422,200.00	300.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	145,500.00	100,000.00	45,500.00	68.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	438,800.00	438,800.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	438,800.00	438,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	438,800.00	438,800.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,919,200.00	71,613,914.00	4,305,286.00	94.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	75,919,200.00	71,613,914.00	4,305,286.00	94.3
320001	Орон нутгийн төсвөөс	75,919,200.00	71,613,914.00	4,305,286.00	94.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13	13	0.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	3	3	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6	6	0.00	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4	4	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2	0.00	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жаргалант сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азхүү гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын Соёлын төв нь нь соёлын үйлчилгээг хөдөөгийн хүн амд хүргэн соёлын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, үндэсний болон орчин үеийн соёл урлагийн үйл ажиллагааг ард иргэд, хүүхэд багачуудад зааж сургах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн төсвийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд “Ардын уламжлалт соёл урлагыг орчин үеийн урлагтай хослуулан хөгжүүлэх оюуны сэтгэлгээний чадавхийг нэмэгдүүлэх ажлын байрны тав тухтай орчинг бүрдүүлэх” зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Соёлын тухай хууль
- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 75.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 0.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 2.9 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	8.6	10.0	1.4	16.2
Үндсэн хөрөнгө	42.8	44.3	1.5	3.5
Нийт хөрөнгө	51.4	54.3	2.9	5.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	51.4	54.3	2.9	5.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	51.4	54.3	2.9	5.6

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 16.2 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 8.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 7.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 6.3 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 10.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 3.5 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 42.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан 2.5 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 7.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 8.9 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 44.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 2.9 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	69.2	75.9	6.7
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	0.08	7.9	7.8
Үйл ажиллагааны орлого	69.3	83.8	14.5
Цалин, шимтгэлийн зардал	59.4	59.7	0.3
Бусад бараа үйлчилгээний зардал	6.4	12.2	5.8
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.6	0.2	-0.4
Бараа үйлчилгээний бусад зардал	7.3	8.9	1.6
Хөрөнгө шилжүүлсэн			0.0
Үйл ажиллагааны зардал	73.7	81.0	7.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4.4	2.8	7.2

Жаргалант сумын соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 6.7 сая төгрөгөөр буюу 9.7 хувиар өссөн нь урсгал зардал нэмэгдэж батлагдсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 83.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 7.9 сая төгрөгөөр хасаж, нийт зардлыг 75.9 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 75.9 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр 71.6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 4.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь урсгал зардалтай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Жаргалант сумын Соёлын төв нь 2021 онд Ковид-19 цар тахлын үеийн дэглэм, улс, аймаг, сумын онцгой комиссоос гаргасан соёл урлагийн үйлчилгээг хориглосон шийдвэрийн улмаас олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулаагүй, өөрийн орлогын төлөвлөгөө батлуулаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 82.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 75.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 71.6 сая төгрөгийг зарцуулж, 94.3 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 26.8 хувь буюу 4.3 сая төгрөгөөн хэмнэлтийг бий болгон ажилласан байна.
2. Тус байгууллага нь өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлгүй бөгөөд албан ажлаар явах зайлшгүй шаардлагатай тохиолдолд бусад байгууллага болон хувь хүний автомашиныг хэрэглэж шатахууны зардлыг олгодог байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллагын 2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 146 мэдээлэл байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроосон байна. 4 дүгээр улирлын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээлээгүй, Мөн төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой 3,085.0 мянган төгрөгийн 4 тушаал шийдвэрийг системд байршуулаагүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомж

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.1 дэх заалтыг дагуу зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлаас 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргана гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 26.8 хувийн хэмнэлтийг бий болгон ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Залруулагдаагүй 1 алдааны дүн 3.9 сая төгрөг нь материаллаг бус тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс үзэхэд 10 нэр төрлийн 3.9 сая төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан байна.

Өгсөн зөвлөмж: Иймд тухайн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Жаргалант сумын соёлын төв	1	3.9							1	3.9
Дүн		1	3.9							1	3.9
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Жаргалант сумын соёлын төв	1	3.1					1	3.1		
Дүн		1	3.1					1	3.1		
Нийт дүн		2	7.0					1	3.1	1	3.9